



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот


Аудитын сэдэв батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагаас 2015 онд хийх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад заасан аудитын сэдвийг үндэслэн 2015 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж, биелэлтэд хяналт тавьж мөрдөж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангадад үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС 2015 ОНД ХИЙХ АУДИТЫН СЭДВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Аудитын сэдэв	Хамрах хүрээ (ТЕЗ)	Хугацаа			Аудитын хүрэх үр дүн
			Эхлэх	Дуусах	УИХ-д хүргүүлэх	
1	2014 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн	Төв болон орон нутгийн ТЕЗ нар	2015.01.02	2015.05.15	2015.06.10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд дүгнэлт гаргаж, УИХ-д хүргүүлнэ
2	Монгол Улсын 2014 эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	Засгийн газар, бүх яамд, нийслэл, орон нутгийн засаг, захиргаа	2015.01.15	2015.03.25	2015.03.31	Үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ
3	Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч	2015.05.10	2015.06.08	2015.06.10	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, УИХ-д хүргүүлнэ
4	2016 оны Монгол Улсын болон орон нутгийн төсвийн төсөлд санал боловсруулах	Сангийн яам, орон нутгийн ТЕЗ-чид	2015.09.20	2015.10.15	2015.10.15	2016 оны Монгол Улсын төсвийн төсөлд санал боловсруулж тайланг УИХ-д хүргүүлнэ.
5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Ажилтай монгол хүн, Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	ЭЗХЯ, СЯ, ХЯ, ХАХЯ, ХААҮЯ, ЭХЯ, УУЯ холбогдох бусад	2015.01.15	2015.06.08	2015.06.25	Ажилтай монгол хүн, Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
6	Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хуулийн хэрэгжилт, үр дүн	СЯ, ТЕГ	2015.08.20	2015.10.20	2015.11.15	Хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.

7	Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, хэрэгжилт, үр дүн	УУЯ, БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2015.08.20	2015.12.20	2016.01.10	Уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль орчны бодлогын хэрэгжилтэд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
8	Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013- 2014 оны үйл ажиллагааны үр дүн	БШУЯ, төрийн өмчит их дээд сургуулиуд	2015.09.20	2016.12.20	2016.02.25	Төрийн өмчит их, дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж УИХ-д хүргүүлнэ.
9	Хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны үр дүн	Монгол-Оросын хамтарсан УБ төмөр зам ХНН	2015.08.20	2016.03.20	2016.03.31	Монгол-Оросын хамтарсан УБ төмөр зам ХНН-ийн 2012-2014 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж УИХ-д хүргүүлнэ.
10	Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт	Аймаг нийслэл сум дүүрэг	2015.02.01	2015.07.01	2015.07.10	Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад аудит хийж, дүнг УИХ-д хүргүүлнэ.
11	Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн	Дархлаажуулалтын, Соёл урлаг хөгжүүлэх, Автозамын сан, ШУТС, Сэргээгдэх ЭХ-ний сан, Орон сууц хөгжүүлэх сан	2015.06.23	2015.11.15	2015.11.25	Засгийн газрын тусгай 5-7 сангийн үйл ажиллагаанд аудит хийж, УИХ-д хүргүүлнэ.
12	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт	Засгийн газар, Монгол Банк	2015.08.01	2015.11.15	2015.11.30	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, зөвлөмж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд хүргүүлнэ.
13	Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт	Засгийн газар	2015.01.10	2015.03.15	2015.03.25	Аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүнг Улсын Их Хуралд хүргүүлнэ.

2014 ОНООС 2015 ОН ДАМЖИН ХИЙХ АУДИТЫН СЭДЭВ

14	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр дүн	Төрийн өмчит эрчим хүчний аж ахуйн нэгжүүд	2014.08.15	2015.01.25	2015.02.01	Төрийн болон орон нутгийн өмчит эрчим хүчний аж ахуйн нэгжүүдэд аудит хийж дүнг УИХ-д танилцуулна.
15	Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн	Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Монголбанк, Хөгжлийн банк	2014.08.15	2014.12.25	2015.01.15	Бонд болон бусад үнэт цаасны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
16	Эрдэнэт ХК-ийн үйл ажиллагааны үр дүн	Эрдэнэт ХК	2014.09.10	2014.12.05	2015.03.15	Хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
17	Концессийн тухай хуулийн хэрэгжилт	Эдийн засгийн хөгжлийн яам, хэрэгжүүлэгч бусад байгууллагууд	2014.08.15	2015.01.15	2015.01.22	Хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
18	Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам	2014.10.15	2015.01.15	2015.01.21	Хуулийн хэрэгжилтэд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
19	УИХ-аас ЗГ-т өгсөн, даалгаврын хэрэгжилт	ЗГ болон төрийн захиргааны байгууллагууд	2014.01.02	2015.04.01	2015.04.10	УИХ-ын Байнгын хороодоос ЗГ-т өгсөн, даалгаврын хэрэгжилтэд аудит хийж, тайланг УИХ-д хүргүүлнэ.
20	Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт	Уул уурхайн яам, Газрын тосны газар	2014.12.20	2015.03.20	2015.03.25	Төсвийн Байнгын хорооны 2014 оны 9 дүгээр сарын 02-ны 0/6127 албан бичгээр 2015 оны эхний улиралд багтаан УИХ-д тайланг хүргүүлэхээр болсон.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО